



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/205

Ховд

Газар эзэмших зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар өмчлөх эрхээсээ татгалзсан иргэний Магсаржав баг Амарсанаагийн 5 дугаар гудамжны 522 тоотод байрлах 1845,5 метр квадрат газрыг “Гэрэл гэгээ наран” ХХК (5818842)-д орон сууцны зориулалтаар 5 жилийн хугацаагаар,

2. Газар өмчлөх эрхээсээ татгалзсан иргэний Буянт баг Эко 3 дугаар гудамжны 5 тоотод байрлах 552 метр квадрат газрыг “Жинстийн Жинчид транс” ХХК (4083563)-д орон сууцны зориулалтаар 5 жилийн хугацаатайгаар тус тус эзэмшүүлсүгэй.

3. Газар эзэмших эрх нь баталгаажсан аж ахуйн нэгж байгууллагуудтай газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Төгөлдөр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.АМАРСАНАА

8400001 2953

Zah A/205 Ba